

# АЖИЛЧДЫН СУДАЛГААНЫ МӨРӨӨР АВСАН АРГА ХЭМЖЭЭ

## PEOPLE SURVEY ACTIONS

GLINT

Your opinion and feedback matters

# ЦАЛИН, УРАМШУУЛЛЫН ХҮРЭЭНД ХИЙСЭН САЙЖРУУЛАЛТУУД

PAY, COMPENSATION AND BENEFIT CHANGES

## ТАНЫ САНАЛЫН ДАГУУ...
YOU SAID: (YOU SPOKE UP)

- Ажилласан цагт хамаарах цалин хөлсийг тухайн сардаа багтаан авах;
- Олговоргүй чөлөө авах үед үндсэн цалингийн бодолтын ойлгомжгүй байдаг талаарх ажилтнууд санал гомдолтой байгааг анхаарах;
- Цалингийн задаргааг ойлгоход амархан, цэгцтэй болгох;

- Employees requested to receive their salaries within the same month the work was performed;
- They also raised ongoing concerns and questions about salary calculation, particularly when taking leave or being absent;
- Additionally, employees asked for payroll information and pay slips to be simplified and made easier to understand;

## ...БИД САЙЖРУУЛЛАА
WE IMPROVED: (WE STEPPED-UP)

**Хамтын гэрээний хэлэлцээрийн дагуу цалин хөлс, урамшуулалтай холбоотой эдгээр сайжруулалтуудыг хийлээ:**

- Тухайн сардаа үндсэн цалин уртын ээлжийн нэмэгдэл ороод дараа сарын 10-ны цалин дээр хэвийн бус илүү цаг, баярын нэмэгдэл ордог байсан нь тухайн сарын 25-ны цалин дээрээ ордог болж өөрчлөгдсөн.
- Сараар цалингийн тооцоолол хийгдэхээр чөлөөтэй үеийн цалингийн тооцоолол илүү хялбар ойлгомжтой болсон.
- Мөн сүүлийн 3 сарын дунджийн тооцоолол маань цагийн бүртгэлийн хамрах хугацаатайгаа таарсан нь ажилтнуудад илүү ойлгомжтой боллоо.

**In line with the Collective Agreement, the following changes related to pay and benefits have been made:**

- While the basic salary and long-shift bonuses were already paid for the same month, overtime and holiday bonuses that were previously added to the salary on the 10th of the following month are now included in the salary on the 25th of the same month.
- Since salary calculations are now done monthly, the leave period calculations have become easier to understand.
- In addition, the average salary calculation for the past three months now matches the timekeeping period, making it more understandable for employees.






# БАЙГУУЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ, АЖЛЫН ХЭРЭГЛЭГДЭХҮҮНИЙ САЙЖРУУЛАЛТ

## FACILITIES, SERVICES AND AMENITIES IMPROVEMENTS

### ТАНЫ САНАЛЫН ДАГУУ...
### YOU SAID: (YOU SPOKE UP)

- Нэг өрөөнд олуулаа байрладаг амрах байрыг сайжруулах;
- Хүртээмжтэй байдал болон хувийн орон зайг хангахад анхаарах;
- Уурхайн цогцолбор болон УБ Моннис оффисын ариун цэврийн өрөөг сайжруулах;
- Ажиллахад тохиромжтой эргономик оффисын ширээ, сандал болон компьютерын дэлгэцтэй болох;
- Оффисын бичиг хэргийн хэрэгслүүдийн олдоц, хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх

- Improve accommodation conditions by reducing the number of people sharing the same room;
- Ensure accessibility and sufficient personal space;
- Upgrade restroom facilities at both the mine site complex and the Ulaanbaatar Monnis office;
- Provide ergonomic office desks, chairs, and PC monitors to create a more comfortable and productive work environment.
- Enhance the availability and accessibility of office stationery and supplies.

### ...БИД САЙЖРУУЛЛАА
### WE IMPROVED: (WE STEPPED-UP)

**МОННИС ОФФИСТ:**

- Ажлын ширээний хүрэлцээ, ашиглалтыг нэмэгдүүлэх зорилгоор ширээ захиалах системийг нэвтрүүллээ;
- 10, 11, 12 давхруудад ажиллахад тохиромжтой эргономик оффисын ширээ, сандал байршуулж холбогдох сайжруулалтуудыг гүйцэтгэлээ;
- 10 давхрын принтерийн өрөөг бүх ажилчдад нээлттэй бичиг хэргийн өрөө болгож шинэчилсэн;
- 00-ын үнэрийг сайжруулах үүднээс оффисын барилгын дээвэр дээр агааржуулалтыг сайжруулах сэнс суурилуулсан;

**AT MONNIS OFFICE:**

- Implemented a hotdesk booking system to increase availability and maximize workstation utilization.
- Installed ergonomic office desks and chairs on the 10th, 11th, and 12th floors to create a more comfortable working environment.
- Converted the 10th-floor printer room into an open stationery/resource room accessible to all employees.
- To improve ventilation and reduce odors in the restrooms, a fan has been installed on the Monnis roof.






# УУРХАЙН ТАЛБАРТ ХИЙСЭН САЙЖРУУЛАЛТ
## SITE IMPROVEMENTS

### СПОРТ ТӨВИЙН ӨРГӨТГӨЛ:

- Спорт төвийн өргөтгөлийн ажил удахгүй дуусах бөгөөд шинэ өргөтгөл дотор эрэгтэй, эмэгтэй фитнес, Монгол наадгай, Жюү жицү, аэробик, ширээний теннис зэрэг өрөөнүүдтэй, нэг давхартаа кофе шоптой, тусгай хэрэгцээтэй зочид/ажилчид ашиглах боломжтой ариун цэврийн өрөөтэй байна.

### RECREATION CENTER EXPANSION:

- The expansion of the Recreation center is nearing completion. The new expansion will feature separate male and female fitness, Mongolian traditional games, Jiu-Jitsu, aerobics, and table tennis rooms. On one floor, there will also be a coffee shop and restrooms accessible to guests or employees with special needs.








# УУРХАЙН ТАЛБАРТ ХИЙСЭН САЙЖРУУЛАЛТ
SITE IMPROVEMENTS

### ЧАНДМАНЬ ОФФИСЫН SPS ТӨВ

- Чандмань оффисын хуучин SPS төвийг нурааж, шинэ хана, тааз, шал, акустик хавтан болон дэлгэцүүдийг байрлуулсан.

### CHANDMANI SPS CENTER:

- In Chandmani office, the old SPS center was demolished, and new walls, ceiling, floor, acoustic panels, and screens have been installed.












## УУРХАЙН ТАЛБАРТ ХИЙСЭН САЙЖРУУЛАЛТ
## SITE IMPROVEMENTS

### АДМИН ОФФИС, ТӨВ СУРГАЛТЫН ТӨВ

- Админ оффисын бүх цонх, Төв сургалтын төвийн зарим цонхыг шинэчиллээ.

### ADMIN, MAIN TRAINING CENTER:

- All windows in the Admin Office, as well as some windows in the Central Training Center, have been replaced.





## УУРХАЙН ТАЛБАРТ ХИЙСЭН САЙЖРУУЛАЛТ
## SITE IMPROVEMENTS

### АРИУН ЦЭВРИЙН ӨРӨӨНИЙ САЙЖРУУЛАЛТ:

- Ариун цэврийн өрөөний хүртээмжийг сайжруулах ажлын хүрээнд Админ оффисын 1,2 давхар, Төв сургалтын төв, спорт заал, шопууд болон бусад оффисуудын эрэгтэй, эмэгтэй ариун цэврийн өрөөг засаж шинэчиллээ.

### RESTROOM IMPROVEMENTS:

- As part of efforts to improve restroom accessibility, the male and female restrooms on the 1st and 2nd floors of the Admin Office, the Main Training Center, the recreation center, the shops, and other offices have been renovated.





## УУРХАЙН ТАЛБАРТ ХИЙСЭН САЙЖРУУЛАЛТ
SITE IMPROVEMENT

### МАЗААЛАЙ ЗООГИЙН ГАЗАР:

- Мазаалай автобусны буудлын саравчийн хавтанг сольж будсан;
- Мазаалай зоогийн газрын дээврийг засаж сайжрууллаа

### MAZAALAI RESTAURANT:

- Mazaalai bus stop shelter panels have been replaced and repainted;
- The roof of the Mazaalai restaurant has been repaired;





## УУРХАЙН ТАЛБАРТ ХИЙСЭН САЙЖРУУЛАЛТ
SITE IMPROVEMENT

### БУСАД САЙЖРУУЛАЛТУУД:

- Ажлын болон амрах байрны тохижилтыг сайжруулах хүрээнд 5J блокуудын халуун, хүйтэн усны шугам хоолойг шинэчилсэн.
- Оюут#2-ын блокуудын коридорт хивсэнцэр дэвссэн.
- Манлай нийтийн амрах байрны блокуудын бүх өрөөний халаалтын шугам хоолой,радиаторыг PPR хоолойгоор сольж сайжруулсан.

### OTHER IMPROVEMENTS:

- As part of improving work and living spaces, the hot and cold water pipelines in the 5J blocks have been replaced.
- Carpets have been laid in the corridors of the Oyuut #2 blocks.
- All heating pipes and radiators in the rooms of the Manlai accommodation blocks have been replaced and upgraded with PPR pipes.





# ХАНБОГД ХОТХОНД ХИЙСЭН САЙЖРУУЛАЛТ
## KB TOWN IMPROVEMENTS

- Өдөр бүр хүндэтгэе хөтөлбөрийн сайжруулалтын хүрээнд, 900 ортой 7 барилгыг Ханбогд хотхонд нэмж түрээсэлснээр 3 хүн хамт байрлах тоог 30%-иар бууруулсан.
- Ханбогд хотхонд ажилчид чөлөөт цагаа өнгөрүүлэх биллиард, ширээний теннис, дартс бүхий өрөөг засаж тохижуулсан.
- Одоо ажилчдын зорчих тав тухыг сайжруулах чиглэлээр, мөн хоол хүнс, ундааны сонголтуудыг нэмэгдүүлэх боломжуудыг судалж байна.

- As part of the Everyday Respect program commitment, seven additional buildings with a total of 900 beds have been leased at the Khanbogd town, reducing 3-person room sharing by 30%.
- A recreation room equipped with billiards, table tennis, and darts has also been renovated for employees to enjoy during their free time.
- We are currently exploring ways to further improve employee mobility and expand food and beverage options.







## УУРХАЙН ЦОГЦОЛБОР ДАХЬ ШИНЭ АМРАХ БАЙР
## NEW PERMANENT EMPLOYEE ACCOMMODATION

- Уурхайн цогцолбор дахь амрах байрны байгууламж хуучирсан, мөн өдөр бүр хүндэтгэе аяны хүрээнд авсан үүрэг амлалтаа биелүүлэх үүднээс уурхайд ээлжээр ажилладаг ажилтнуудад зориулсан байнгын амрах байрны бүтээн байгуулалтын ажил эхлээд байна.
- Хуучин “Мастер гэр кэмп”-ийн байршилд таван давхар, нийт 1,120 өрөөтэй дөрвөн блок бүхий шинэ амрах байр баригдаж байна. Энэхүү шинэ байр ашиглалтад орсноор 2,200 гаруй ажилтан орчин, үеийн тав тухтай сууцад байрлах боломж бүрдэх юм.

- As the existing accommodation facilities at the mine site are reaching the end of their service life, construction has begun on a new permanent accommodation facility for shift employees in line with our Respect Every Day commitment.
- The new five-story complex, consisting of four blocks with a total of 1,120 rooms, is being built on the site of the former Master Ger Camp. Once completed, it will provide modern, comfortable housing for more than 2,200 employees.
























Location - 2
Fuel station
Location - 1
Location - 3

# ХАМТЫН СОЁЛЫГ БЭХЖҮҮЛЭХ САНААЧИЛГУУД

INITIATIVES TO STRENGTHEN OUR COLLECTIVE CULTURE

## ТАНЫ САНАЛЫН ДАГУУ...
YOU SAID: (YOU SPOKE UP)

- Шийдвэр гаргалт удаан, хариуцлагын эрх хэмжээ тодорхой бус;
- Хүнд суртал бүхий олон шатлал бүтэц, процесстой;
- Нэгж хэлтэс хоорондын уялдаа холбоотой хамтын ажиллагаа сул, салангид үйл ажиллагаатай болохыг онцолжээ.

- Decision-making is slow, with too many layers and unclear accountabilities.
- Processes are complex and overlapping.
- Cross departmental collaboration and alignment are weak, with siloed operations.

## ...БИД САЙЖРУУЛЛАА
WE IMPROVED: (WE STEPPED-UP)

**БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ШИНЭЧИЛСЭН ЗАГВАР:**

- “Хөгжил дэвшлийг хамтдаа бүтээе” стратегитайгаа байгууллагын үйл ажиллагааг уялдуулан сайжруулах хүрээнд байгууллагын үйл ажиллагааны загварыг шинэчилсэн. Шинэчилсэн загварын дагуу Оюу толгойн удирдлагын түвшнээс анхан шатны удирдлагын багууд хүртэлх бүх түвшинд зохион байгуулалтаа хянан нягталж, шаардлагатай өөрчлөлтүүдийг хэрэгжүүлсэн.
- Энэ нь ажиллах арга барилыг хялбарчлан, шийдвэр гаргалтыг түргэсгэж, үүрэг, хариуцлага болон гүйцэтгэлийг илүү тодорхой болгох нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэж байна. Ингэснээр гүйцэтгэлийг байгууллагын бүх түвшинд сайжруулж, өндөр бүтээмжтэй багуудыг төлөвшүүлэх болно.

**REFRESHED OPERATING MODEL:**

- In alignment with our 'Creating Prosperity. Together' strategy, we have refreshed our organisational operating model to successfully deliver on our strategic objectives. Aligned with the operating model principles, organisational structures at all levels—from leadership to frontline teams—have been reviewed, and accompanying changes are being implemented to support and ensure effective operation under the refreshed model.
- This change focuses on simplifying how we operate, speed up decision-making, and bringing greater clarity over roles, responsibilities, and deliverable expectations at all levels. Through this we aim to empower high-performing teams across the organization.

# ХАМТЫН СОЁЛЫГ БЭХЖҮҮЛЭХ САНААЧИЛГУУД

## INITIATIVES TO STRENGTHEN OUR COLLECTIVE CULTURE

### ...БИД САЙЖРУУЛЛАА
WE IMPROVED: (WE STEPPED-UP)

**ОЮУ ТОЛГОЙН БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛТОТ СОЁЛ:**

- Бид байгууллагын “ Анхаарал халамжтай, Зоримог шийдэмгий, Сониуч соргог “ байх үнэт зүйлсээ өдөр тутмын ажилдаа шингээн ажлын байр болгонд, өдөр бүр харагдаж, мэдрэгдэхүйц ямар сэтгэлгээ болон зан үйлээр харуулж болохыг тодорхойлсон.
- Энэхүү зан үйлүүд нь бид хамтдаа илүү сайн ажиллаж, бие биеэ дэмжин, үр дүнтэй хамтран ажиллах соёлыг бүрдүүлэхэд чиглэнэ.
- Энэ сэтгэлгээ, зан үйлийг хамт олондоо үлгэрлэн, өдөр тутмын ажлын арга барилдаа хэвшүүлэхэд туслах зорилгоор удирдах ажилтнуудыг хамруулсан семинарыг зохион байгуулан ажиллаж байна.

**OYU TOLGOI’S TARGET CULTURE:**

- To consistently and meaningfully embed our values into everyday work, we have defined what the qualities of Care, Courage, and Curiosity look like in practice—through specific mindsets and behaviours that are visible, relatable, and repeatable in every role, every day.
- This shared understanding and mindset enable us to work better together, support one another as internal customers, and foster a culture of effective collaboration.
- To reinforce these mindsets and behaviours, leadership workshops are being conducted to help senior leaders role-model them and embed them into daily work practices. Leaders play a critical role in shaping our culture, setting expectations, and influencing behaviours across the teams.





# ХАМТЫН СОЁЛЫГ БЭХЖҮҮЛЭХ САНААЧИЛГУУД

INITIATIVES TO STRENGTHEN OUR COLLECTIVE CULTURE

## ТАНЫ САНАЛЫН ДАГУУ...
YOU SAID: (YOU SPOKE UP)

- Удирдлагууд харилцааны чадвар, баг удирдах чадавхаа сайжруулах
- Ажилчид хоорондоо харилцаа хандлагаа сайжруулах, бие биеэ хүндэтгэх

- Leaders to focus on communication, and team leadership capability
- Improving communication and mutual respect among employees

## ...БИД САЙЖРУУЛЛАА
WE IMPROVED: (WE STEPPED-UP)

**"АЖЛЫН БАЙРАН ДАХЬ ДЭЭРЭЛХЛИЙН ЭСРЭГ" НӨЛӨӨЛЛИЙН АЯН:**

- Хүндлэл, оролцоог дэмжсэн ажлын орчны соёлыг хэвшүүлэх хүчин чармайлтын хүрээнд "Ажлын байран дахь дээрэлхлийн эсрэг" нөлөөллийн аяныг 2025.03.01-2025.09.01-ний хооронд амжилттай зохион байгууллаа.
- Аяны хүрээнд зохион байгуулагдсан яриа, хэлэлцүүлгээр бид нэг нэгнээ хэрхэн хүндэтгэн харилцах ёстой, хүндэтгэлийг сонгох боломж бидэнд өдөр бүр байдаг талаар эргэцүүлж, санал солилцсон.

**ANTI-BULLYING AT THE WORKPLACE AWARENESS CAMPAIGN:**

- As part of our ongoing efforts to promote respect and inclusion in the workplace, the “Anti-Bullying at the Workplace” Awareness Campaign was successfully implemented from March 1 to September 1, 2025.
- Through panel sessions, workshops, and team conversations, we challenged ourselves to look closely at how we interact with one another and how we can choose respect every day.







GLINT

Your opinion and feedback matters